



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 8/5/6

Улаанбаатар хот

Г
Өндөржүүлсэн бэлэн байдлын үеийн
эмнэлгийн тусlamж, үйлчилгээг хангах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Улсын онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 12 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТУШААХ** нь:

1. Өндөржүүлсэн бэлэн байдалтай холбоотой эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал наарт дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай. Үүнд:

1.1. КОВИД-19 халдварын цартахлаас урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусlamж үйлчилгээний бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тодотгол хийж, хэрэгжилтийг хангаж ажиллах;

1.2. Бэлэн байдлын болон хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан халдвар хамгааллын дэглэм, бусад арга хэмжээнүүдийг тодотгож, 2020 оны 11 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд байгууллагын бэлэн байдлаа шалгаж, төлөвлөгөөг дахин нягталж, бэлэн байдлыг хангудлаа шаардагдах төсөв, холбогдох бусад тооцоог гаргаж шийдвэрлүүлэх;

1.3. Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний бэлэн байдлыг хангаж, эмнэлгийн ор дэлгэх, нөөц эмнэлэг ажиллуулах бэлтгэлийг хангах;

1.4. Хүний нөөц, эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, оношуур, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, хэрэгсэл, ариутгал, халдвартгүйтгэлийн бодис, хчүилтөрөгчийн хангамж, унаа шатахууны нөөцийг бурдүүлэх;

1.5. Эрүүл мэндийн ажилтнуудын дархлааг сайжруулах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх;

1.6. Эмнэлгийн халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээрх ажлыг батлагдсан зааврын дагуу камериин хяналтанд хатуу чанд мөрдөж ажиллах;

1.7. Улсын онцгой комиссын 2020 оны 4 дүгээр албан даалгавар “Маскаа зүүе, гараа угаая” аяныг чанартай зохион байгуулж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэл, сурталчилгааг эрчимжүүлж, эрүүл мэндийн байгууллагын нэвтрэх хэсэгт

иргэдийн халууныг тогтмол хэмжих, ажиллагсад, үйлчлүүлэгчдэд маск тогтмол зүүлгэж, маскгүй хүнд үйлчлэхгүй байх арга хэмжээг авах;

1.8. Хамгаалалтын хувцас өмсөх, тайлах дараалал, бэлэн байдлын үед ажиллах горимын талаарх сургалтыг биечлэн болон цахим хэлбэрээр тогтмол зохион байгуулж ажиллах;

1.9. Байгууллагын дотоод хөдөлгөөний урсгалыг зохицуулж, эмчлүүлэгчийн сахиур, арга гэрийн эргэлтэд хязгаарлалт хийх;

1.10. Олон нийтийг хамарсан уулзалт, сургалт, семинар зохион байгуулахгүй байх;

1.11. Үйлчлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчдийн аюулгүй байдал, хувь хүний нууц, мэдээллийн аюулгүй байдлыг хангах;

1.12. Эрсдэлт бүлгийн хүн амын судалгааг 14 хоног тутамд шинэчлэн нягталж, Эрүүл мэндийн яаманд ирүүлэх;

1.13. Эрчимт эмчилгээний тасгийг цахимжуулах, лавлагагаа төвөөс цахим зөвлөгөө авах боломжийг бүрдүүлэх.

2. Энэхүү тушаалыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны менежер /О.Чимэдсүрэн/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд /Ш.Анхмаа/-д даалгасугай.

САЙД



Т.МӨНХСАЙХАН